



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН  
“ХҮНДЭТ ДЭВТЭР”



ХҮНДЭТ ДЭВТЭР  
КНИГА ПОЧЕТА







Шагдарсүрэнгийн Жигжидсүрэн

1976 оноос УКТЭ-н удирдлага зохион байгуулалтыг ШУ-ны үндэстэй болгон сайжруулах, эмчилгээний чанарын үзүүлэлтэд өөрчлөлт гаргаж, эмч нарыг нарийн мэргэжлээр мэргэшүүлсэн.

1981.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №1



Гонгийн Лхагважав

1977 онд Анестези-реанимацийн тасгийг эмнэлгийн 1.5 хувьд үйлчлэхээр зохион байгуулж 6 эмч, 18 сувилагчийг мэргэжилдээ сурган стационарын эндэгдлийг бууруулсан.

1981.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №2



Данаажавын Баарайн

ШБОС-78-д эмнэлгийн хяналтын самбарыг санаачлан хийж, ШБОС-80-д уур үүсгэгч тогоо хийж оновчтой саналын эрхээ хамгаалж, эмнэлгийн дэргэдэх ШСН-н зөвлөлийн даргаар 7 жил идэвхи зүтгэлтэй ажилласан.

1981.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №3



Пэлжээгийн Онхуудай

1976 онд Цөмийн онош-зүйн лабораторийг нээн ажиллуулж 20 нэр төрлийн шинжилгээний арга нэвтрүүлсэн.

1981.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №4



Хүдэрхүүгийн Тэрбиш

Эрүүлийг хамгаалах системд анх удаа гемодиализийн төвийг байгуулан 120 хүнийг 378 удаа диализид оруулж эндэгдлийг 65 хувь бууруулсан.

1981.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №5



Авирмэд овогтой Отгондалай

Мэс засалч эмчээр ажиллаж буй хугацаандаа шинийг санаачилж, БНАГУ-н Шарито-гийн клиникийн туршлагаар хөнгөн өвчтөнг бямба гарагт гэрт нь түр гаргадаг болсноор эрүүлийг хамгаалах системийн хэмжээнд үр дүнтэй өөрчлөлт болсон.

1989.03  
ХҮНДЭТ ДЭВТЭР №6



Гончигсэнгээгийн Нямхүү

Мэс засалч эмчээр ажиллаж буй хугацаандаа элэг цэс, ходоод нойр булчирхай, бүдүүн шулуун гэдэсний өвчнүүд болон өрцөн дээр байрласан бэтгийг эмчлэхэд амжилт гаргасан.

1989.03  
ХҮНДЭТ ДЭВТЭР №7



Оньдогойн Лхамсүрэн

Харшил судлалын эмчээр ажиллаж буй хугацаандаа төрөл бүрийн аллергей ба гистоглобулин эм санаачлан үйлдвэрт шилжүүлэн, харшлаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, ном идэвхтэй бичиж байсан.

1989.03  
ХҮНДЭТ ДЭВТЭР №8



Намнандоржийн Нямдулам

Эрчимт эмчилгээний тасагт ажиллаж байх хугацаанд захын хураагуур судсанд гуурс тавих аргачлал, чийглэгчтэй маскаар хүчилтөрөгч өгөх, амьсгалын замын аппаратын хоолой гуурсуудыг ариутгах арга зэргийг ажилдаа нэвтрүүлж эмчилгээг хөнгөвчилсэн.

1997.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №9





Даваагийн Цэнд

Улсад 34 жил ажилласнаас Эмнэлгийн боловсон хүчин, хүн хүчний алба, хүний нөөцийн менежер зэрэг албыг 27 жил хашсан эрүүл мэндийн удирдлагын ажилтан. Тус хугацаанд хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэхийн тулд ажлын гүйцэтгэлийг дүгнэх, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ зэрэг байгууллагын дотоод эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгосон 2003.01.28-ны өдөр №10 гэрчилгээ олгосон.

2003.01.28  
ХҮНДЭТ ДЭВТЭР №10



Нанзадын Батцэнгэл

1967 оноос тасралтгүй 37 жил ажиллах хугацаанд Бигэрийн бөөрний сувиллыг байгуулалцаж, 1991 оноос Уламжлалт эмнэлгийн кабинет нээн ажиллуулж улмаар өргөжүүлж өргөжүүлэн тасаг болгон ажилласан.

2004 он  
ХҮНДЭТ ДЭВТЭР №11



Муухайн Намсрай

Бөөрний дуранг анх санаачлан байгуулж бөөр шээсний доод болон дээд замын 9 төрлийн шинжилгээг нэвтрүүлж 20 гаруй ШБОС нэвтрүүлж патент авсан. Түүрүү булчирхайн дурангийн оношилгоо, эмчилгээний асуудал сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалж улмаар “Төрийн шагнал” хүртэж, 2008 онд Монгол улсын “Хүний гавьяат эмч” цол хүртэж амжилттай ажилласан.

2011 он  
ХҮНДЭТ ДЭВТЭР №12



Даваажав овогтой Нямсүрэн

1977 оноос Эрүүл мэндийн салбарт, 1989 оноос УНТЭ-н Урологийн эмчээр ажиллаж байна. тус хугацаанд 1996 онд багийн хамт Монгол улсад анх удаа бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг эхлүүлсэн ба 2006.06.29-ний өдөр багийн хамт анх удаа хүүхдэд бөөр шилжүүлэн суулгасан. 1996 оноос 2005 он хүртэл УКТЭ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар, 2005 оноос одоог хүртэл БМЗК-н эрхлэгч, одоог хүртэл зөвлөх эмчээр ажилласан.

2011.12.28  
ХҮНДЭТ ДЭВТЭР №13



Sung Gyu Lee

1973 оноос БНСУ-ын Эрүүл мэндийн салбарт, 2010 оноос УНТЭ-н Элэг шилжүүлэн суулгах багтай хамтран ажиллаж байсан. 1993.03 дугаар сард Солонгос улсад анх элэгний үүд хэсгийн хавдрыг тайрч, 1994 онд хүүхдэд элэг шилжүүлэн суулгах, 1998.01 сард Дэлхийд анх удаа амьд донороос элэгний баруун дэлбэнг шилжүүлэн суулгах мэс засал хийсэн. 2010 оноос эхлэн УНТЭ-н Элэг шилжүүлэн суулгах багтай хамтран 13 удаагийн элэг шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай хийж нэвтрүүлсэн.

2014.02.23  
ХҮНДЭТ ДЭВТЭР №14



Нямдаваа овогтой Туул

АУ-ны салбарын хөгжил, гадаад харилцаа хамтын ажиллагаа тэлж, шинэ технологи нэвтэрч, хамт олныг чадварлаг менежментээр удирдсанаар клиник нь Гастроэнтерологийн төв болж өргөжин олон улсын жишиг хандлагаар тусламж, үйлчилгээ үзүүлэх алхам тавигдсан. Монгол улсад элэг шилжүүлэн суулгах технологи нэвтрүүлэхэд оролцон элэг шилжүүлэн суулгахын өмнөх, дараах хяналт эмчилгээг хийж байна.

2015.03.05  
ХҮНДЭТ ДЭВТЭР №15





## БАТЧУЛУУН ОВОГТОЙ ТӨМӨРБААТАР

1975-1976 онд Хөвсгөл аймгийн Галт, тариалан сумдад, 1977-1983 онд Говь-Алтай аймгийн Алтай сумын улсын улсын хилийн хорооны хүн амын эмнэлгийн салбарын эрхлэгчээр, мэс заслын блок байгуулж хөдөө орон нутгийн ард иргэд болон цэргийн албан хаагчдад 150 гаруй мэс заслыг хийж гүйцэтгэсэн. 1983-1991 онд НАХЯ-ны төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, 1991-2012 онд УНТЭ-н Ерөнхий мэс заслын тасгийн их эмч, зөвлөх эмчээр, 2012 оноос “Ачтан” клиникийн эмнэлэгт мэс заслын тасгийн зөвлөх эмчээр тус тус ажилласан.

2015.04.22

ХҮНДЭТ ДЭВТЭР №16

## ГЭНДЭН ОВОГТОЙ ЦЭРЭНБАДАМ



1985 оноос УНТЭ-т тасралтгүй үр бүтээлтэй ажилласан. 2004 онд эмнэлгийн дулааны системд техник технологийн шинэчлэл хийж "Ялтсан бойлер"-ыг суурилуулснаар эмнэлгийн дулаан хангамж сайжирч, шугам сүлжээний гэмтэл багасч, дулаан нэмэгдсэн. 2014 онд цахилгааны ерөнхий тэжээлийн 0,6 кв-ын дэд өртөөг УБЦТС ХК-н зүүн түгээх төвтэй хамтран 140 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, трансформаторыг шинэчилснээр цахилгааны асуудал бүрэн шийдэгдсэн.

2015.05.13

ХҮНДЭТ ДЭВТЭР №17

## НОРОВ ОВОГТОЙ ОЮУНДЭЛГЭР



1984 оноос хойш тасралтгүй ажиллах хуагацаанд Монгол улсад анх удаа ясны хэмт эдийн шийнжилгээг цитратанд авч түэхц бэлтгэн харах арга, ясны чөмөгний эдийн шинжилгээг пкпрактикт нэвтрүүлж, цусны гоожимтгой эмгэгүүдийн ялган оношилгоонд Виллебрандын фактор, тромбоз бүхий эмгэгүүдийг оношлоход Д-Димерийг ашигласан, Нера-фильтр өрөө, аферез эмчлгээ болон цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний технологийг нутагшуулж байгаа анхны мэргэжилтэн юм.

2015.09.17

ХҮНДЭТ ДЭВТЭР №18



## СОДОВ ОВОГТОЙ СОНИН

1987 онд УНТЭ-т эхографийн эмчээр томилогдон ирж хэвлийн хөндийн эхографийн оношлогоог амжилттай нэвтрүүлэж, эх орныхоо бүхий л ЭХО-н эмчнарын бэлтгэсэн. 1992-1996 УКТЭ-н Эмчилгээ эрхэлсэн захирал, 1999-2000 онуудад Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны сайд, 2007-2008 онуудад эмнэлгийн дарга, эрдэмтдийн зөвлөлийн даргаар ажиллаж Монгол улсад анх удаа вакум хагалгааний өрөөг байгуулсан.

2015.09.17  
ХҮНДЭТ ДЭВТЭР №19



## ЛАМЖАВ ОВОГТОЙ САРАНЦЭЦЭГ

2006 онд эмнэлгийн мэдээллийн технологийн төслийг улсын төв эмнэлэгт санаачлан анх удаа амбулаторийн хэсгийн бүртгэл, үзлэг шинжилгээг хамруулан санаачлагатай ажилласан нь түүхэн гавъяа юм. 2016 онд УНТЭ-т хэрэгжиж буй “Цахим эрүүл мэнд” төслийн багийн ахлагч, зөвлөхөөр ажиллан нарийн чимхлүүр удирдлагыг хэрэгжүүлж олон шинэ технологиудыг нэвтрүүлсэн.

2016.12.23  
ХҮНДЭТ ДЭВТЭР №20



## ОРГОЙ ОВОГТОЙ СЭРГЭЛЭН

2007 онд элэг шилжүүлэн суулгах туршилтын мэс заслын төслийг ШУТС-н санхүүжилтээр эхлүүлж 26 гахайд элэг шилжүүлэн суулгах туршилтын мэс заслыг хийсэн бөгөөд элэг шилжүүлэн суулгах багийг анхлан зохион байгуулж, үндэмний багийн ахлагчаар ажиллаж байна. 2009 онд элэг шилжүүлэн суугах эмчилгээний удирдамжийг боловсруулж 2010 онд ЭМЯ-аар батлуулсан. 2015 онд 6 орны 18 төлөөлөгч оролцсон ЭШС олон улсын анхдугаар хурлыг зохион байгуулж даргалан явуулсан. Манай улс дэлхийд элэг шилжүүлэн суулгасан 46 дахь орноор бүртгэгдсэн. 2014 онд анх удаа 2 хүүхдэд, 2015 онд нэг хүнд цогцосны донороос элэг шилжүүлэн суулгасан.

2017.11.02  
ХҮНДЭТ ДЭВТЭР №21





## ЛУВСАНДОРЖ ОВОГТОЙ АМГАЛАН

Ерөнхий мэс заслын тасгийг удирдах хугацаанд эмнэлгийн хэмжээнд 2 удаа тэргүүн байр, 3 удаа шагналт байрт шалгарсан бөгөөд мэс заслын идэвхи 98%-д хүрч, дундаж ор хоног 6.0 болтол буурсан үзүүлэлт нь давтагдашгүй амжилт юм. Түүний санаачлагаар УНТЭ-н ХНТ-т битүүмжлэгдсэн хагалгааны өрөөг анхлан байгуулж ашигласан нь Монгол улсад анхных байхаас гадна томоохон мэс заслуудыг хийх нөхцлийг бүрдүүлсэн.

2018.09.21  
ХҮНДЭТ ДЭВТЭР №22



## MAURICE SLAPAK

2006 ОНД Монгол улсад бөөр, элэг шилжүүлэн суулгах багийн эмч нарыг сонгон шалгаруулж, бөөр шилжүүэн суулгах мэс ажилбарыг үр дүнтэй нэвтрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. 2009 онд Гемодиализын 20 ширхэг аппарат тус эмнэлэгт хандивлаж гемодиализын хүртээмжийг нэмэгдүүлсэн, 2013 онд Ариутгалын тасгийг Вакум өрөөтэй болгон тохижуулж шинэ иж бүрдэл тоног төхөөрөмжөөр хангасан.

2018.12.05  
ХҮНДЭТ ДЭВТЭР №23



## БӨӨР ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ҮНДЭСНИЙ БАГ

Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн ерөнхий захирлын тушаалаар 2006 онд Бөөр шилжүүлэн суулгах үндэсний баг байгуулагдан орчин үеийн анагаах ухааны технологи болох Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээг Монгол улсад нэвтрүүлэн өдгөө 200 гаруй мэс засал хийгдээд байна.

2020.01.15  
ХҮНДЭТ ДЭВТЭР №24



## ЭЛЭГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ БАГ

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2011 оны А/244 тоот тушаалаар элэг шилжүүлэн суулгах үндэсний баг байгуулагдан Анагаах ухааны хөгжлийн оргилын нэг болох элэг шилжүүлэн суулгах өндөр технологийг өөрийн оронд нэвтрүүлэн хөгжүүлж өдгөө 100 гаран мэс заслын эмчилгээ хийгдээд байна. богино хугацаанд амьд болон тархины үхэлтэй донороос элэгний зүүн, баруун дэлбэн, бүтэн элэг шилжүүлэн суулгах зэрэг бүхий л шилдэг технологиудыг нэвтрүүлсэн.

2020.08.21

ХҮНДЭТ ДЭВТЭР №25

ДОРЖ ОВОГТОЙ ЧУЛУУНЦЭЦЭГ

1984 оноос одоог хүртэл баг хамт олноо чадварлагаар удирдан манлайлж ажиллахын зэрэгцээ Монгол улсад бөөр судлалын болон гемодиализ, хэвлийн диализ эмчилгээний тусламж, үйлчилгээг хөгжлийн шинэ шатад хүрэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. Бөөрний эмгэгийн оношилгоо, эмчилгээ, бөөр орлуулах эмчилгээний технологийн сайжруулан нутагшуулах, гемодиализын эмчлүүлэгчдийг хянах, хүндрэлээс сэргийлэх ID карт, биопси, плазмофорез эмчилгээний технологийг нэвтрүүлж амжилттай хөгжүүлж байна.



2021.10.25

ХҮНДЭТ ДЭВТЭР №26





ЦУСНЫ ҮҮДЭЛ ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ БАГ  
Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 171 тоот тушаалаар 29 хүний бүрэлдэхүүнтэй "Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах үндэсний баг" анх байгуулагдсан нь Монгол улсад Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг нэвтрүүлэн нутагшуулах ажлыг 2011 оноос эхлүүлж, технологийн орчин нөхцөл, чадамжит хүний нөөц бүрдсэн тогтолцоог бэлтгэн, 2014 онд анхны тохиолдлоо амжилттай гүйцэтгэснээс хойш эдүгээ өөрөөс нь өөрт нь үүдэл эс шилжүүлэн суулгах /ауто/ 31 дэх эмчилгээгээ хийгээд байна.

2023.07.05  
ХҮНДЭТ ДЭВТЭР №27



### ДУРАНГИЙН СУУЛГАЦЫН МЭС ЗАСЛЫН БАГ

2009 онд Чихний дунгийн суулгацын мэс заслын технологийг нэвтрүүлэх саналыг хэлэлцүүлэн дэмжүүлснээр Монгол улсад 2009 оны 08 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд төрөлхийн сонсголгүй болон шалтгаан тодорхойгүй хүнд хэлбэрийн сонсгол бууралттай 2 хүүхдэд анхны мэс заслыг амжилттай хийжээ. Улмаар 2014 оны 01 сард УНТЭ-ийн Ерөнхий захирлын тушаалаар Дунгийн суулгацын мэс заслын эмчилгээний багийн бүрэлдэхүүн болон тус эмчилгээний удирдамжийг батлуулж, технологийн тасралтгүй хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж ажилласаар эдүгээ 199 хүнд амжилттай гүйцэтгээд байна.

2023.07.05  
ХҮНДЭТ ДЭВТЭР №28